



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 109

Номгон

Г

Т

Үндсэн хөрөнгө балансаас  
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, “в”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

- Хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ, Галуут сумын Эрүүл мэндийн төвд ашиглагдаж байгаа 2 нэрийн 37,532,151 төгрөгийн өртөг бүхий тээврийн хэрэгслийг хавсралтын дагуу балансаас балансад үнэ төлбөргүй шилжүүлсүгэй.
- Баянлиг сумын Цагдаагийн кабон нь аймгийн Цагдаагийн газарт бүртгэлтэй тул 625м<sup>2</sup> талбай бүхий эзэмшил газрыг аймгийн Цагдаагийн газарт шилжүүлэхийг Баянлиг сумын Засаг дарга /А.Бадмаадарж/-д даалгасугай.
- Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан ажлын зохион байгуулж ажиллахыг даалгасугай.
  - Тухайн байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг комисс томилон, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;
  - Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
  - Энэ тогтоолын хэрэгжилтийг 2018 оны 10 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэх.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.





Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүпэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын  
19-ний өдрийн 109 дүгээр толоолын хавсралт

### БАЛАНСАAS БАЛАНСАД ШИЛЖУУЛСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Аймаг /сум/-ын нэр	Байгууллагын нэр	Эд хөрөнгийн нэр	Ашиглал танц орсон огноо	Хүнж ийн сийж ийн огноо	НБҮ	Бүгд үнэ	Элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авсан байгууллагын нэр	
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Баянхонгор аймаг	Баянхонгор тохиижилт үйлчилгээ ОНОДАТУГ	Кран	15.04.15	6	1	18500000	18 500 000	6 012 499,95	12 487 500,05	"Баянхонгор-Эрчим хүч" ЦГТХХК-д
2	Галуут сум	ЭМТ	УАЗ-469 Автомашин 11- 58БНА УАЗ- 31512 Марктай	13.12.25	10	1	19032143	19 032 143	7 137 053,55	11 895 089,45	Аймгийн Цагдаагийн газарт
			ДҮН				2		13 149 554	24 382 590	